

Эрхэм хүндэт эцэг, эхчүүд ээ !

Манай зуны сургуульд хүүхдээ явуулахаар шийдсэн танд талархал илэрхийлье.Төвд Монголын Шашин Соёлын Төв, Ажаа Гэгээнтэний санаачилгаар Монголын Соёлын Төв, Монгол Америкийн Нийгэмлэгтэй хамтран монгол хүүхдүүдэд зориулсан зуны зусланг энэ жил бид бас хоёрдох удаагаа зохион байгуулахаар болоод байна. Зусланд хүүхдүүд зөвхөн амрах төдийгүй, нарийн бэлдсэн хуваарийн дагуу хичээл заалгаж, монгол дуу бүжиг суран, Индианагийн Их Сургуулийн монгол судлаач, эрдэмтэн багш нарын яриа лекцийг сонсох болно. Мөн өөр хотоос ирсэн үе тэнгийнхэнтэйгээ уулзан нөхөрлөж, бие биенээсээ ч бас ихийг сурах буй заа.

Ингээд та бүхэн бүртгэлийн хүснэгт болон монгол хэлний талаарх асуулгыг бөглөн зуслангийн төлбөр 180 ам. долларын чекийн хамт доорх хаягаар илгээнэ үү. Асууж лавлах зүйл байвал 812-325-5337 утсаар Саранцэцэгтэй холбоо барина уу.

Tibetan Mongolian Buddhist Cultural Center  
Mongolian Children Summer Camp  
3725 S.Snoddy Rd.  
Bloomington, IN 47401

Хүүхдүүдийн монгол хэлний мэдлэгийн талаарх асуулга.

1. Хүүхдийн овог, нэр
2. Монголд сургуульд явж байсан эсэх  
Явж байсан бол хэддүгээр анги хүртлээ хэдэн жил Монголд сурсан
3. Монголоор ойлгох чадвар  
а.чөлөөтэй  
б.сайн  
в. дунд зэрэг  
г. муу  
д. ерөөсөө ойлгодоггүй
4. Монголоор унших чадвар  
а. сайн  
б. дунд зэрэг  
в. муу  
г. ерөөсөө уншиж чадахгүй



